

## Сэтгүүлчпийн эрхийг хамгаалахад үйлдвэрчний эвлэлийн гүйцэтгэх үүрэг

**Ч.Чойсамба**, сэтгүүл зүйн доктор, дэд профессор

Үйлдвэрчний эвлэл (Trade unions) бол хөдөлмөрчдийн эдийн засгийн эрх ашгийг хамгаалах зорилгоор байгуулагдсан ажилчдын сайн дурын, мэргэжлийн нэгтгэл юм.

XVII-XVIII зуунд Европын орнуудад капиталист харилцаа хөгжихийн хирээр нийгэм-эдийн засгийн шинэ ангиуд бүрэлдэн тогтсон нь үйлдвэрийн эзэд буюу ажил олгогчид, хөлсний ажилчид байжээ. Тэдний хоорондын харилцаа анхнаасаа л зөрчил, хямралтай байв. Капиталист харилцаа дөнгөж хөгжиж байсан тэр үед ажил олгогчид ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд ажлын өдрийг уртасгах, хөдөлмөрийн хөлсийг багасгах, үл ялиг зөрчилд торгууль ногдуулах, хөдөлмөр хамгааллыг гаргуунд нь хаях, ажлаас халах зэргээр хөлсний ажилчдын хөдөлмөрийг элдвээр шулж мөлжих нь энгийн үзэгдэл болжээ.

Анхны үйлдвэрчний эвлэл тухайн үед аж үйлдвэрлэл хамгийн өндөр хөгжсөн Англид үүссэн нь зүй ёсны юм. Энэ оронд ҮЭ үүсч, хөгжсөн замнал дэлхийн бусад орнуудад хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах ижил төстэй хөдөлгөөнүүдийн түүхээс нэг их ялгаагүй байжээ.

Хөдөлмөрчдийн анхны эвлэлүүд орон нутгийн шинж чанартай байсан бөгөөд зөвхөн тэргүүний салбаруудын нарийн мэргэшлийн, өндөр ур чадвартай ажилчдыг эгнээндээ нэгтгэж байв. 1792 онд Ланкаширт утас ээрэгчид эрх ашгаа хамгаалахаар эвлэлдэн нэгдсэн нь түүхэнд анхны ҮЭ болон тэмдэглэгджээ.

Үйлдвэрийн эзэд, тэдний ашиг сонирхлыг илэрхийлэгч төр ҮЭ-ийг үүссэн цагаас нь эхэлж үл тэвчих хандлага гаргах болсон байна. ҮЭ-ийг «хуйвалдааны байгууллага» гэж зарлаж, гишүүнээр элссэн хэн боловч ч эрүүгийн хариуцлага тооцож, хөдөлмөрчдийн эвлэлийг хориглосон тусгай хуулиудыг батлан гаргах болжээ. 1799-1800 онд Англид ажилчдын цуглааныг хууль бус гэж зарласан, жагсаалыг хориглосон хуулиуд ар араасаа батлагдсан байна. Гэвч эдгээр хууль ажилчдын эрх ашгаа хамгаалах зориг эрмэлзлийг мохоосонгүй, харин ч улам бадраажээ. Ажилчид Англи даяар ҮЭ-үүд байгуулж, гишүүнээр нь элсэх болсон байна. Үүний үр дүнд Английн парламент 1824 онд ҮЭ-үүдийг арга буюу хүлээн зөвшөөрч, эсрэг хуулиудыг цуцалсан юм<sup>1</sup>.

---

<sup>1</sup> <http://www.krugosvet.ru/articles/109/1010983/1010983a1.htm>

ҮЭ-үүд үүсэхэд хүргэсэн шалтгааныг аваад үзвэл ажил олгогч, ажилчдын ашиг сонирхлын хоорондох зөрчил байжээ. Тэгэхдээ ганцаараа чадахгүйг хамт олноороо хөдөлбөл бүтээж болохыг ажилчид ухамсарласанд хэргийн гол учир оршино. Хэрэв хөлсний ажилчин үйлдвэрийн эзний санал болгосон ажлын нөхцөл, цалингаас татгалзвал ажлаасаа халагдах нь тодорхой. Үйлдвэрийн эзэн ажилтнаа халснаар өчүүхэн ч хохирохгүй бөгөөд оронд нь өөр хүн авах боломж нь үргэлж нээлттэй байдаг. Харин ажлаасаа халагдсан ажилчин дахин ажилд ортлоо ямар ч орлогогүй явдаг учир хохироод өнгөрдөг. Ажлын нөхцлөө сайжруулах, цалингаа нэмүүлэхийн тулд ажилчин зөрчил үүссэн тохиолдолд хамт ажиллагсдынхаа дэмжлэгийг авч чадсан цагт сая амжилтанд хүрэх магадлалтай. Ганц нэг ажилчин эсэргүүцлээ илэрхийлэх, ажил хаяхад үйлдвэрийн эзэнд эмзэглээд байх зүйл үгүй. Харин ажилчид бүгд нэгдэж, дуу хоолойгоо нийлүүлбэл энэ нь нийтийн ажил хаялтад хүргэх, улмаар үйлдвэрлэл зогсож, алдагдал хүлээх аюултай учир эзэд арга буюу тэдний санал хүсэлтийг сонсох, цаашлаад заримыг нь биелүүлэх хүрдэг. Тиймээс ҮЭ ажил олгогчтой хамтын гэрээ байгуулах замаар төлөөлж буй гишүүн нэг бүрийнхээ эрх ашгийг хамгаалдаг ажээ. Ганц нэгээрээ тэмцээд амжилтанд хүрч чадахгүй ажилчид хамтын хүчээр эрх ашгаа хамгаалж чаддаг учир ҮЭ-үүд үүссэн цагаасаа хойш өдийг хүртэл оршсоор байна.

ҮЭ-ийн мөн чанарыг судалдаг орчин үеийн эрдэмтэд энэхүү байгууллагын үндсэн хоёр үүргийг онцолдог. Энэ нь: нэгдүгээрт, хамгаалах; хоёрдугаарт, төлөөлөх үүрэг юм. Хамгаалах үүрэг нь ҮЭ—ажил олгогчийн хоорондын, төлөөлөх үүрэг нь ҮЭ—төрийн хоорондын харилцааг зохицуулдаг. Эдийн засагчид үүн дээр эдийн засгийн буюу гурав дахь үүргийг нэмдэг. Энэ үүрэг нь ажлын нөхцлийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгддэг.

ҮЭ-ийн үүсэл, зорилго, үүргийн тухай өгүүлсний дараа дэлхийн зарим улс оронд сэтгүүлчдийн ҮЭ ямар үйл ажиллагаа явуулдаг, ямар үр дүнд хүрсэн тухай хэдэн баримт дурдъя.

Өмнөд Солонгост ардчиллын үйл явц өрнөхөд үүссэн сэтгүүлчдийн ҮЭ-үүд нь ХМХ-ийн эзэд, эрхлэн гаргагчид болон редакциудын бүтээлч ажилтнуудын хооронд дэгдсэн маргаан, зөрчлийг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Анхны ийм ҮЭ 1987 оны 10-р сард өдөр тутмын «Ханьгүг илбо» сонины редакци дээр байгуулагджээ. Үүний араас богино хугацаанд олон тооны ҮЭ үүссэн байна. Тиймээс Хөдөлмөрийн яам 1988 оны 1-р сард редакцийн

ажилтнууд, ажил олгогчид бүрэлдэхүүнд нь орсон хамтын зөвлөл байгуулахыг эрхлэн гаргагч болгонд үүрэг болгожээ. Энэ нь сэтгүүлчдийн ҮЭ-ийг засгийн газрын буюу дээд төвшинд хүлээн зөвшөөрч, хууль ёсны статустай болгосны илрэл байв. 1988 оны 4-р сард байгуулагдсан Хэвлэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн үндэсний зөвлөл сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах, хүсэлт, шаардлагыг нь ажил олгогчдод хүргэхэд үйл ажиллагаагаа чиглүүлжээ. Энэ үеэс эхлэн ажил олгогчид, сэтгүүлчдийн хооронд үүссэн аливаа үл ойлголцол, маргаан ужгирч, даамжралгүй харилцан ашигтай зөвшилцөлд хүрснээр ихэвчлэн өндөрлөх болсон юм. Эзэд буулт хийхээс татгалзсан тохиолдолд ҮЭ-үүд эцсийн арга хэмжээ болох ажил хаялтад уриалдаг байв. 1988 оны 7-р сард орон нутгийн «Пусан илбо» сонины ҮЭ Өмнөд Солонгосын сэтгүүл зүйн түүхэнд анхны ажил хаялтыг зарласан байна. Үүний үр дүнд тус сонин зургаан өдрийн турш гаралтаа зогсоожээ. Гагцхүү эзэд нь редакцийн шаардлагаар редакторыг ажлаас нь халж, хамт олны санал болгосон хүнийг энэ албан тушаалд томилсны дараа л сэтгүүлчид ажилдаа гарсан байна. Энэ явдлаас хойш эзэдтэйгээ хэл амаа ололцож чадаагүй сонины сэтгүүлчид ажил хаяж байсан тохиолдол хэд хэд гарчээ.

ХМХ-ийн удирдлагууд ҮЭ-д таатай хандаагүй нь мэдээж юм. Тухайлбал: «Сегие илбо» сонины ажилтнууд үйлдвэрчний эвлэл байгуулах гэхэд Мүн Сан Мен ламтан тун ч шулуун хариу өгчээ. ҮЭ-тэй сонинтой байснаас огт сонингүй байсан нь дээр гэж түүнийг мэдэгдэхэд бүгд нам гүм болсон байна<sup>2</sup>.

1989 оны 1-р сард сэтгүүлчдийн ҮЭ-ийн хөдөлгөөн шинэ байгууллагаар баяжжээ. Сонин, сэтгүүлийн 41 үйлдвэрчний эвлэл, 13 мянган гишүүн үүсгэн байгуулалцсан Солонгосын хэвлэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо 1989 оныг «хэвлэлийг чөлөөлөх» тэмцлийн эхний жилээр тунхаглаж, редакциудын ажилтнуудын ажлын нөхцлийг сайжруулах, мэдээллийн салбарт хараат бус байдлыг бий болгох, ардчилсан байгууллагуудтай нягт холбоо тогтооход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлсэн юм.

Сэтгүүлчдийн ҮЭ-үүдийн эхний гурван жилийн үйл ажиллагаа тэдгээрийн өндөр үр нөлөөг харуулсан байна. Чухамхүү ҮЭ-ийн ачаар хөдөлмөрийн хамт олон эзэдтэйгээ зарчмын асуудлуудаар тохиролцож чаджээ. Тухайлбал, ХМХ-ийн ажилтнуудын цалинтай амралт, баярын өдрийн тоог нэмж, цалин нь тухай хэвлэлийн борлогдох хувь зэрэг үзүүлэлтээс хамаарч байхаар шийдсэн байна. Түүнээс гадна ХМХ-ийн эзэд ажилтнууддаа хоол, унааны зардалд тодорхой

---

<sup>2</sup> Far Eastern Economic Review, 1 Nov. 1990, p. 31.

хэмжээний мөнгө гаргаж, мөн хүүхдүүд нь сургуульд сурах хугацаанд гарах зарим зардлыг төлж байхаар тогтжээ.

1997-1998 онд Зүүн-Өмнөд Азийн орнуудад нүүрлэсэн эдийн засгийн хямрал “бар” хэмээгддэг улсуудад илүү хүнд туссан юм. Хямрал Өмнөд Солонгосын эдийн засгийг төдийгүй, сэтгүүл зүйг ч бүхэлд нь тамирдуулсан юм. 1998 оны 4-р сар гэхэд сэтгүүлчдийн арми эрс цөөрчээ. Солонгосын хэвлэлийн ҮЭ-үүдийн холбооны мэдээллээр 1997 оны сүүл, 1998 оны эхний улиралд нийтдээ 8 мянга орчим сэтгүүлчийг хэвлэлийн редакциуд халсан байна. Зөвхөн өдөр тутмын сонинууд л гэхэд 3900 ажилтнаа халж, орон тоогоо 17300 хүн болтол (үүнээс Сөүлд 10544 хүн) цомхотгожээ. Сэтгүүлүүд дээргүй байдалд ороод байв. 1998 оны 1-р хагаст 177 сэтгүүл шинээр бүртгэгдсэн нь 1997 оны 1-р хагасаас 101-ээр цөөн байлаа. Мөн хугацаанд 261 сэтгүүл эсвэл дампуурсан, эсвэл гаралтаа зогсоосон нь 1997 оны 1-р хагас жилтэй харьцуулбал 111-ээр их байв<sup>3</sup>.

1997-1998 оны эдийн засгийн хямрал Өмнөд Солонгосын хэвлэлийн хөгжлийг нэлээд хэмжээгээр чөдөрлөсөн юм. Олон тооны сонин, сэтгүүл дампуурч, гаралтаа зогсоож, хэвлэлийн компаниуд банкнаас авсан зээлээ эргүүлж төлж чадахгүй үйл ажиллагаагаа хумиж, олон мянган сэтгүүлч ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн байна. ХМХ-ийн ажилтнуудын эрх ашгийг үүссэн цагаасаа хойш хамгаалсаар ирсэн Солонгосын хэвлэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо хямралын нөхцөлд өөрөө тарж бутрах дээрээ тулжээ. Учир нь олон сонин, сэтгүүл дампуурлаа зарлаж, гаралтаа зогсоосноос хойш ҮЭ-үүд нь оршин тогтнохоо больсон байна. Өмнөд Солонгосын сэтгүүл зүйн түүхэнд 1998 онд хамгийн хүнд жил болжээ. Энэ онд 8000 орчим бүтээлч болон техникийн ажилтан халагдсан юм. Мөн онд 10 жилийнхээ ойг тэмдэглэж байсан Солонгосын хэвлэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо ҮЭ-үүдийг хадгалан үлдэж, сэтгүүлчдэд туслахын тулд хамаг хүч чадлаа шавхсан байна<sup>4</sup>.

Хямралын үеэр ҮЭ-үүдийн холбооны дэмжлэг, тусламжтайгаар сэтгүүлчид, редакцийн ажилтнууд эрх ашгийнхаа төлөө тэмцэж эхэлжээ. Тэд цалин хөлсөө нэмүүлэх, орон тоог цомхотгохгүй байх зэрэг шаардлага тавьж байв. Угаасаа ОНМХ-ийн гэлтгүй улс орны байдал нэн бэрх байсан учир сэтгүүлчдийн тэмцэл тэр бүр амжилтанд хүрээгүй ч зарим нэг асуудал дээр ажил олгогчид буулт хийсэн юм. Тухайлбал, эдийн засгийн «Мэ-иль бизнес ньюзпэйпер» сонины ҮЭ

<sup>3</sup> A Handbook of Korea. 1999, pp. 406, 408.

<sup>4</sup> Ё ò ó ã ë î â Ä. Ä. İöãññà Ææííé Êîðàë. İññêââ, 2005, ñ. 102.

удирдлагатайгаа ярилцаад, шинээр гарч буй ажлын байрыг эхлээд халагдсан хүмүүст санал болгоно, тэд татгалзсан тохиолдолд шинэ сурвалжлагчийг ажилд авч байхаар тохиролцоонд хүрчээ. Түүнчлэн жирийн сэтгүүлчид, удирдлагын аппаратын төлөөлөгчид бүрэлдэхүүнд нь орсон хороо редакци дээр байгуулагдаж, ажлаас халах, орон тоог цомхотгох асуудлыг хэлэлцэж, шийдэж байхаар болов. Өмнөд Солонгосын сэтгүүл зүйг жинхэнэ утгаар нь хараат бус болгохын төлөө ҮЭ-үүд уйгагүй тэмцэж, ихээхэн үр дүнд хүрсэн юм.

Ер нь аль ч байгууллагын удирдлага, цаашлаад төр ажилчид эрх ашгаа хамгаалахаар ҮЭ-д эвлэлдэн нэгдэхэд таатай хүлээж авдаггүй. Энэ тухай Украины сэтгүүлчдийн ҮЭ-ийн дарга Сергей Гус: «Улс төрийн цензурыг илчилж, устгах зорилготой тэмцэж эхлэхэд биднийг бараг л хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байгаа юм шиг хүлээн авч, ҮЭ-д үл итгэх хандлагыг сэтгүүлчдийн дунд хүчээр суулгаж байсан» гэж ярьсан байдаг. Энэ саад бэрхшээл, дайсагнасан хандлагыг ҮЭ-үүд тойрч биш, дайрч өнгөрдөг жамтай. Ингэж чадсан тохиолдолд ҮЭ гишүүдийнхээ эрх ашгийг бодитойгоор хамгаалах боломжтой болдог.

Хамгийн нөлөө бүхий сэтгүүлчдийн ҮЭ-тэй орнуудын нэг бол яах аргагүй Финлянд юм. Сэтгүүл зүй өндөр төвшинд хөгжсөн энэ оронд ҮЭ үүссэн түүхийг аваад үзвэл сонирхолтой. 1921 онд ХМХ-үүдийн 11 ҮЭ хуралдаж, Финляндын сурвалжлагчдын ҮЭ-үүдийн нэгдлийг байгуулснаа зарлажээ. Шинэ байгууллага ажлаа аахар шаахар асуудлуудаас эхэлсэн байна. Тухайлбал, сурвалжлагч нарт үнэмлэх олгох, төрийн мэдлийн төмөр замаар зорчиход хөнгөлөлт үзүүлэх, гадаадад мэргэжил дээшлүүлэхэд төсвөөс мөнгө олгох зэргээс ҮЭ үйл ажиллагаагаа эхэлжээ. 1967 онд ажил олгогчтой хөдөлмөрийн анхны гэрээ байгуулагдсан байна. 1972 онд Финляндын сурвалжлагчдын ҮЭ-үүдийн нэгдэл 10 өдөр 10 цаг үргэлжилсэн анхны ажил хаялтыг зохион байгуулсан юм. Үүний үр дүнд сэтгүүлчдийн цалин хөлс тодорхой хэмжээгээр нэмэгджээ. Хоёр дахь ажил хаялт 1980 онд болж, гурван долоо хоног үргэлжилсэн байна. Ажлын долоо хоногийг багасгасан, олон жилийн нэмэгдэл, амралтын мөнгийг нэмсэн, мөн ажлын цагаар хурал хийх эрхийг нь баталгаажуулсан гэрээ байгуулагдсаны дараа л сэтгүүлчид ажилдаа гарчээ. 1988 онд зохиогдсон гурав дахь ажил хаялт сэтгүүлчдийн цалингийн зөрүүг багасгахад нөлөөлжээ<sup>5</sup>.

Өнөөдөр Финляндын сэтгүүлчдийн ҮЭ-үүдийн холбоо эгнээндээ 15 мянган гишүүн нэгтгэж байна. Тус холбоог бүрдүүлдэг 19 салбар ҮЭ-ээс хамгийн том нь Радио, телесэтгүүлчдийн холбоо бөгөөд 4500 гишүүнтэй.

---

<sup>5</sup> [www.centrasia.ru/newsA.php?st=1226468760](http://www.centrasia.ru/newsA.php?st=1226468760)

Финляндын сэтгүүлчид яагаад ҮЭ-дээ итгэл үзүүлж, бараг бүгдээрээ гишүүнээр нь элсэн орсны учир юу вэ? 2006 онд тэдний дунд явуулсан санал асуулга үүний шалтгааныг илрүүлжээ. ҮЭ сэтгүүлчийг ажлаас халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгодог, ажил дээр хурцадмал, зөрчил нөхцөл байдал үүсэхэд эв зүйгээр зохицуулахад нөлөөлдөг, цалин хөлсийг нэмүүлэх асуудлыг нааштай шийдвэрлүүлдэг, хөдөлмөрийн зах зээл болон хөдөлмөрийн гэрээний нөхцлийн тухай ашигтай мэдээлэл олгодог, гишүүддээ хөнгөлөлт (үнэгүй сонин захиалдаг, элдэв төрлийн даатгалд хамрагддаг г. м.) үзүүлдэг байна. Түүнээс гадна ҮЭ-ийн гишүүн байх нь тухайн хүн мэргэжлийн сэтгүүлч болохыг илэрхийлж, нэр төрийн баталгаа болдог, улмаар редакци, студийн хамт олон доторх байр сууриа баталгаажуулдаг ажээ.

Монголтой олон талаараа ижил төстэй Казахстаны сэтгүүлчдийн ҮЭ-ийн байгууллага дээр одоо тогтож ярьж байна. 2008 оны 11-р сарын байдлаар тус улсад 2760 тогтмол хэвлэл, теле-, радиосуваг үйл ажиллагаа явуулж байсны 80 хувь нь төрийн бус ХМХ юм. Үг хэлэх эрх чөлөөг хамгаалах «Адил соз» сангийн ерөнхийлөгч Тамара Калеевагийн ярьснаар: «Төрийн бус ХМХ бол хараат бус, чөлөөт ХМХ мөн гэж урт удаан хугацааны турш үнэн голоосоо итгэж байсан. Харамсалтай нь тийм биш болохыг амьдрал харуулсан. Өмнөх тогтолцооны үеийн намын хараа хяналтыг цензурын өөр хэлбэрүүд бүрэн дүүрэн орлоод байна».

Түүний үзэж буйгаар, ОНМХ төр засгийн тавьсан аялгуунд бүжиглэж байгаа нь хэд хэдэн шалтгаантай аж. Нэгдүгээрт, ОНМХ-ийн монопольчлол улам бүр газар авч байна. 2007 оныг хүртэл ОНМХ-ийн хамгийн том эзэмшигч нь Казахстаны ерөнхийлөгч Нурсуртан Назарбаевын охин Дарига, түүний нөхөр Рахат Алиев байжээ. Өнгөрсөн жил төрийн гэмт хэрэгтнээр зарлагдаж, 40 жил хоригдох ялаар шийтгүүлсэн Алиев эх орноосоо дүрвэж, одоогоор Австрид орогнож байна. Харин Дарига Назарбаевагаас ОНМХ эзэмших эрхийг нь хураан авчээ. Тэдний эзэмшиж байсан телевизийн хамгийн том сувгийг төр худалдан авсан байна. Казахстаны сэтгүүлчид жилийн жилд л ОНМХ-ийг монопольчлолын эсрэг хууль батлахыг шаарддаг ч Соёл, мэдээллийн яамны сайд, парламентын гишүүд эрс татгалздаг ажээ.

Хоёр дахь хүчин зүйл бол ОНМХ-ийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж юм. Энэхүү хууль сэтгүүлчдийн хувьд залхаан цээрлүүлэх илэрхий агуулгатай. 1999 онд батлагдсан ОНМХ-ийн тухай хуульд 2007 оныг хүртэл жил

бүр нэмэлт, өөрчлөлт оруулж байсан бөгөөд эдгээр нь сэтгүүлчдийн эрхийг улам бүр хумиж, тэдний эсрэг авах арга хэмжээг чангатгаж буй юм.

Хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлаж буй өөр нэг ноцтой хүчин зүйл бол сэтгүүлчдийн мэргэжил, хууль эрх зүйн хангалтгүй мэдлэг, боловсрол ажээ. Казахстанд сэтгүүл зүйн 17 их, дээд сургууль мэргэжилтэн бэлтгэдэг ч редакци, студиуд цаг ямагт чадварлаг боловсон хүчнээр гачигдаж байдаг нь сонирхолтой. Т.Калеевагийн оновчтой ажигласнаар: «Хэрэв сэтгүүлч эрхэлсэн ажилдаа өнөөдрийн зүсэм талхаа олох хэрэгсэл мэтээр хандаж байгаа бол сэтгүүл зүй хэзээ ч дөрөв дэх засаглалын үүргээ бодитойгоор хэрэгжүүлж чадахгүй».

Тав дахь хүчин зүйл нь Казахстаны сэтгүүлчдийн нийгмийн хамгаалалтгүй, мэргэжлийн хувьд эв нэгдэлгүй байдал юм. Одоог хүртэл Казахстанд сэтгүүлчдийн мэргэжлийн холбоо байгуулагдаагүй, ОНМХ-ийг эзэмшигч, сэтгүүлчдийн харилцааг зохицуулсан заалт хуулинд байдаггүй.

Т.Калеева энэ бүхний эцэст Казахстаны сэтгүүлчид ҮЭ-д эвлэлдэн нэгдэх зайлшгүй шаардлагатай юм гэж дүгнэсэн байдаг<sup>6</sup>.

Тажикстанд сэтгүүлчдийн байдал дээргүй байгаа юм. Тажикстаны Чөлөөт олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үндэсний холбооны дарга Нуриддин Каршибоев: «Гадны хүн сонсоод итгэдэггүй юм. Сэтгүүлчдийг ажлаас халдаг 13 тохиолдол бий. Гэтэл сэтгүүлчид 1-2-оос илүү тохиолдлыг мэддэггүй, учир нь тэдэнд хэлдэггүй. Өнөөдөр сэтгүүлч эзнээсээ бүрэн хамааралтай, түүний атганд байгаа» гэжээ. Мэргэжлийн ямар ч холбоод эздэд юу ч гэж хэлээд тэд тоодоггүй байна. «Сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалж, редакци доторх хараат бус байдлыг хангаж чадах цорын ганц байгууллага бол яах аргагүй ҮЭ юм» гэж Н.Каршибоев үзэж байна.

Казахстан, Тажикистанд сэтгүүлчдийн ҮЭ байхгүйгээс ямар бэрхшээлтэй асуудлууд байна вэ?

Хоёр редакци, студи болгоны нэгэнд нь ажлын өдрийн нормчилсон хязгаар байдаггүй, илүү цагаар ажилласны хөлс гэдэг ойлголт үгүй, хөдөлмөрийн хөлсний баталгаат доод хэмжээ үгүй, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлөгддөггүй байна.

**“XIX зүйл ба эрх зүйн орчин” дугуй ширээний ярилцлага  
2008.12.08**

<sup>6</sup> <http://www.tazar.kg/news.php?i=9513>